



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 58/
32-с/

Сүхбаатар сум

Зөрчил арилгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан 2025 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн СХШ-2025/05/ТШЗ дугаартай удирдамжийн дагуу Сэлэнгэ аймгийн Орхон бүсийн сум дундын ойн ангийн 2024 он, 2025 оны 3-р улирлын төсөв, санхүү, үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт шалгалтаар худалдан авалтын цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй, бараа ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээг бөөн дүнгээр бүртгэсэн нийт 2,249,650.0 (Хоёр сая хоёр зуун дөчин есөн мянга зургаан зуун тавин төгрөг)-ийн худалдан авалтын анхан шатны баримтын шаардлага хангаагүй зөрчил илэрлээ. Үүнд:

- 2024 онд 1,141,000.0 (Нэг сая нэг зуун дөчин нэгэн мянган төгрөг)
- 2025 онд 1,108,650.0 (Нэг сая нэг зуун найман мянга зургаан зуун тавин төгрөг)

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.", 13.6 дахь "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна."Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

4325007155

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ." гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авалтын цахим төлбөрийн баримтыг худалдан авагчаас бөөн дүнгээр шивүүлэхгүй байх.
2. Цаашид дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллаж биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэхийг Орхон бүсийн сум дундын ойн ангийн дарга Э.Сувдаа, нягтлан бодогч А.Баярмаа нарт даалгав.
3. Улсын ахлах байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.
4. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ
Т.ОДСҮРЭН

ЗӨВШӨӨРСӨН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОН
БҮСИЙН СУМ ДУНДЫН ОЙН
АНГИЙН ДАРГА
Э.СУВДАА
НЯГТЛАН БОДОГЧ
А.БАЯРМАА